



Ятгасан эсээ

МОНГОЛ ХЭЛ 12-Р АНГИ

III УЛИРЛЫН 5-Р ХИЧЭЭЛ

МХБУЗ-ЫН БАГШ Б.ЭНЭБИШ

ENEBISH@MUST.EDU.MN 99003930



Хичээлийн зорилго

Ятгасан эсээ бичих аргад
суралцах



Хичээлийн зорилт

- ❖ Ятгасан эсээ гэж юу вэ мэдэх
- ❖ Ятгасан эсээг бичих аргад суралцах
- ❖ Загвар эсээн дээр ажиллах



Эсээ

Эргэцүүлэн бодох элдэв дүгнэлтүүдээс бүтэх, хийсвэрлэн сэтгэх чадвараас шалтгаалсан, туурвин бичилтийн үзэл бодлын зөрчлийн хэлбэрээр илрэн гардаг бичлэгийн хэв маягийг эсээ гэнэ. Товчоор хэлбэл, баримтаас үүдсэн хувь хүний эргэцүүлэл юм.



Эсээ нь дараах төрөл зүйлтэй байна

- ❖ түүх
- ❖ гүн ухаан
- ❖ уран сайхны
- ❖ эрдэм шинжилгээний хялбаршуулсан
- ❖ уран зохиолын
- ❖ намтарчилсан
- ❖ нийтлэлийн
- ❖ утга зохиол шүүмжлэлийн

Бичих зорилго

Эсээг бодит байдал болон бусдын бичсэн бүтээсэн зүйлсийг судалж, түүнд үнэлгээ дүгнэлт өгч, баталж нотолж, уг зүйлийн талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх зорилгоор бичдэг.

Эсээг юуны тулд бичдэг вэ?

Сургалт болон судалгааны ажлын явцад ажигласан болон уншиж судалсан зүйлдээ тулгуурлан тодорхой сэдэв, асуудлаар өөрийнхөө ойлголт, бодол эргэцүүлэл, итгэл үнэмшлийг эсээгээр илэрхийлдэг.



Ятгасан эсээ түүний бүтэц

Удиртгал	Үндсэн хэсэг	Шийдэл
1. Суурь мэдээлэл өгнө 2. Байр сууриа илэрхийлнэ 3. Уншигчдын анхаарлыг татна	1. Байр сууриа дэмжинэ 2. Эсрэг үндэслэлийг хүлээн зөвшөөрөх юм уу няцаана	1. Байр мууриа дахин дэмжинэ 2. Зохистой гэж үзвэл үйлдэлд уриална.

Удиртгал

Анхаарал тат: Сонирхолтой баримт статистик, утга төгс эшлэл, аамьдралын сорилт, туршлагаас үүдэлтэй, товч хүүрнэлээр анхаарлыг татаж, асуудалд төвлөрүүлнэ.

Суурь мэдээлэл: Үндэслэлээ ойлгуулахад чиглэсэн ямар нэг суурь

/дэвсгэр/ мэдээлэл өгнө.

Мэдүүлэх: Асуудлын талаар баримталж байгаа байр сууриа тодорхой тууштай илэрхийлнэ. Баримталж байгаа байр суурь тодорхой бус бол уншигчдын итгэл алдахад хүрнэ.



Үндсэн хэсэг

Итгүүлэх нөхцөл бүрдүүл: Учир зүй, сэтгэл хөдлөл, ёс зүйн арга хэрэглүүрийг оновчтой хослуулж, байр сууриа дэмжиж, нотолно. Тэгэхдээ байр суурьт гурваас доошгүй шалтгаан бүрд хоёроос доошгүй нотолгоо байна.

Хоёр талаас авч үз: Байр суурийг тань зөвшөөрөхгүй байгаа ухаалаг тусч хүний байранд өөрийгөө тавиад үз. Тэр хүн ямар үндэслэл нотолгоо гаргаж ирэх бол гэж эргэцүүл. Түүнийг нь аль нэг талаар хүлээн зөвшөөрөх юм уу эрс няцаана.



Шийдэл

Амжилттай төгсгө: Байр сууриа дахин илэрхийлж уншигчдад сануулна.

Уншигчдад нөлөөл: Асуудлын талаар уншигчдын хийх зүйл байгаа бол гүйцэтгэхийг зөвлөнө. Таны эсээ тэдний үйлдэлд түлхэц болно.



Ятгасан эсээг бичихдээ дараах алхмаар төлөвлөнө.

1. Байр сууриа сонгох:

Асуудлыг аль талаас нь сонгож бичих вэ?

Ямар үр дүнг санал болгох гэж байна вэ?

2. Уншигч сонсогчоо судлах

Эсээг хэнд зориулж бичиж байна вэ?

Таньтай санал нэг байх уу эсвэл эсэргүүцэх үү?

Сонгосон сэдвийн талаар сонсогч юу мэдэж байгаа бол?

3. Сэдэв сонгох: Мэдлэг туршлагаас тань илүү олон зүйл шаардагдах учраас уг сэдвийн талаар нарийн судалсан хүмүүстэй ярилцах, номын санд сууж эрэл хайгуул хийх, хэрэгтэй.

4. Эсээг төлөвлөн бичих: Төлөвлөгөө гарган эсээ бичих загварын дагуу бичих



Загвар эсээ

Талхигдлаас үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготны хэт олшролт л аварна

Тийм ээ, малын хөлийн талхигдал буюу бэлчээрийн даац хэтэрснээс үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготны хэт олшролт авардаг аа гэдгийг малчид маань тэр тусмаа монгол ухаанаа гээж, төрөл арилжаагүй малчид бол сайн мэдэж буй нь лавтай. Эхний өгүүлбэр юуг агуулж байна вэ? Зохиогчийн байр суурийн илэрхийлэл мөн үү?

2013 оны 9-р сард Байгаль орчин ногоон хөгжлийн сайд дарга нар цөлжилтийн шинэ атлас гарсныг танилцуулж, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 72 хувь нь тодорхой зэрэглэлээр цөлжилтийн аюулд өртлөө гэдгийг телевизээр дамжуулж мэдэгдэж байсан юм.

Зохиогч энэ баримтыг дурдсаны учир юу вэ? Иймээс өнөөгийн төр засаг, аймаг сумдын удирдлагууд цөлжилтийг зогсоох, бууруулах, арилгах талаар тун яаралтай арга хэмжээ авч ажиллах нь хэнд ч ойлгомжтой асуудал болов уу. Тиймээс ч өнөөдөр оготноо устгах тухай их ярьж байна. Монгол орны говь, тал хээрийн бүс нутгуудад цөлжилт нүүрлэх урьдчилсан нөхцөл шалтгаан чухам юунаас болж үүсдэг, мөн тэр нь эргээд байгаль эхийн өөрийнх нь дотоод зохицуулалтаар хэрхэн гайхамшигтайгаар нөхөн сэргээгдэж, унаган төрхөө хэвийн хадгалан авч үлддэг байсан байж болох талаар товчхон хөндье. Монголын тал хээрийн бүсийн өнгөн хэсэг гэгддэг үржил шимт давхарга нь харьцангуй нимгэн байдгаас түүнийг хүүхдийн зулай мэт эмзэгхэн хөрс гэж үздэг. Иймээс хөрсний эвдрэлд амархан орж, цөлжилт нүүрлэн цааш хурдацтай тархаж болох аюултай бүс юм. Хөрсний энэхүү эвдрэл доройтол чухам юунаас голлон шалтгаалж үүсдэг вэ гэвэл бэлчээрийн даац хэтэрснээс гэж шуудхан хэлж болно. Талхигдлаас үүссэн хөрсний энэхүү нягтрал хатуурлыг цааш даамжрахаас сэргийлж эс чадвал тухайн газар нутаг бэлчээрийн гүн доройтолд орж, улаан сайр болон хувирах аюул нүүрлэдэг юм. Тэгвэл энэхүү бэлчээрийн гүн доройтолд орж, чулуужин хатуурч буй үхмэл хөрсийг сийрэгжүүлэн зөөлрүүлж, мөн түүнийг элдэв төрлийн ялзмаг, ялгадсаар баяжуулан бордож, нар салхи, ус чийг нэвтрүүлэн, улмаар ургамлын үндсийг уртасгах нөхцөлийг бүрдүүлж, өтгөн шигүү өвс ургамалтай, соргог сайхан бэлчээр нутаг болгон хувиргах тэр гайхамшигт технологийн үүргийг хэн гэгч ачтан буянтан гүйцэтгэж чадах вэ гэдэг асуудал одоо эндээс гарах нь лавтай болов уу

Зохиогч үгийг налуулж онцолсны учир юу вэ?

Тийм ээ, энэхүү туйлын хүнд хэцүү нүсэр их ажлыг гагцхүү ҮЛИЙН ЦАГААН ОГОТНО хэмээгч *хорголжин бор нүдэт, хурдан шалмаг, нөр их хөдөлмөрч, бяцхан амьтад л нуруундаа үүрч, зүтгэхээс өөр хэн ч үүнийг гүйцэтгэж үл чадах* тийм нарийн технологи шаардсан үйл ажиллагаа гэж хэлж болно. Одоо үүний үнэн худлыг нотлохын тулд нөхөн төлжих чадвар нь муудсан тэрхүү үхмэл хөрсийг огтоно хэмээгч энэхүү бяцхан амьтад ямар гайхамшигт арга технологиор хэрхэн яаж дахин сэргээж амьдруулдаг байж болохыг авч үзэцгээе. Энэ тухай А.А.Таракановский, Г.Амарсанаа, Ц.Одбаяр нарын зэрэг эрдэмтэн судлаачдын 1980-аад бүтээлээс товчхон эш татъя. "... өвс ургамал сайтай бэлчээр нутаг жил дараалан малын хөлд талхигдсанаас хөрс дагтаршиж, ургамал сийрэгжин, улмаар оготно олшрох таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Зохиогч яагаад эрдэмтэн судлаачдын бүтээлээс эш татав? Ийнхүү 10-14 жилийн зайтайгаар оготно хэт олширч, тухайн нутгийн ургамлыг идэж хоосолсноор хүн, мал, амьтад бүгд дайжин нүүж, тэр орчин нутаг талхигдах эдэлгээнээс түр ч болов амсхийдэг байна. Оготно олшрох үедээ нэг га-д 1000 гаруй толгой оногдож, өдөрт дунджаар 4-5 кг, жилдээ 2 тн орчим ялгадас гаргаж, хөрсийг борддог. Мөн хөрсийг хавж сэндийчлэн, хааш хаашаа 1 метр газарт 4, нэг га-д 40000 нүх малтаж, талхагдаж дагтаршсан хөрсийг агааржуулан сийрэгжүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. **Эдгээр тоо баримтыг юуны учир оруулав?**

Нөгөө талаар нүх ухах явцад газрын гүнээс өнгөн хэсэгрүү эрдэс бодис эргэдэг онцлогтой. Оготны хэт олшролт нь цаашдаа өөрсдийгөө дарамтад оруулж, үржил нь зогсонги болж, мөхөлд хүргэдэг юм. Ийнхүү оготны нөлөөгөөр иж бүрэн сайжирсан хөрсөнд 2-3 жилд зүйл бүрийн ургамал ургаж, ургац хэд дахин нэмэгддэгийг олон жилийн судалгаа харуулдаг.

Энэ бүхэн бол хөрсийг бэлчээрийн доройтолд оруулахгүй амрааж байх өөрийн дотоод зохицуулалтыг байгаль эх заяаж буйн гайхамшиг юм. Үлийн цагаан оготно бидний дайсан биш ээ ..." хэмээн онцолжээ.



Энэ бол үлийн цагаан оготно хэмээгч ач буянтан хэт олширсныхоо хүчээр хийж буй үнэхээрийн гайхамшигт нөхөн сэргээлт бөгөөд бүх ургамлыг нь хөрсөн доор нь оруулж, бүрэн гүйцэт бордлоо гэсэн үг. Үнэндээ, монголын говь тал хээрийн бүсэд бэлчээрийн даац хэтэрснээс үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготно хэмээгч энэ гайхамшигт технологичид аварна уу гэхээс өөр хэн ч аварч чадахгүй гэдгийг энэхүү нөхөн сэргээлт харуулах болов уу. Иймээс бид одоо чоныг байгаль эхийн цэвэрлэгч санитар хэмээн нэрлэдэг шигээ үлийн цагаан оготно бол байгал эхийн маань цагаан нөмрөгт гоо сайханчид гэвэл харин ч дэгсдэхгүй бололтой. **Зохиогч дээрх хэсэгт ямар санааг давтав?** Байгаль эх энэхүү гайхамшигт нууцыг ашиглаж, өвс ихтэй, хөрс зөөлөн ойт хээрийн бүсийг бус, харин малын хөлөөр амархан дагтаршиж хатуурдаг, маш эмзэгхэн тал хээрийн бүсэд цөлжилт нүүрлэх үед нь онцлон сонгуулах хэмээн их хурдацтай үржин тархаж олширдог үлийн цагаан оготно гэгч энэхүү хурдан шалмаг, нөр их хөдөлмөрч бяцхан амьтадыг бүтээж буй болгосон нь ойлгомжтой юм... Тиймээс оготно олшроод ирэнгүүт л бидний суудал ихдэж газар дэлхийдээ даац хэтрүүлэн дарамт үүсгэснээс тэнгэр эцгийн ивээлээр оготно олширлоо хэмээн ухаарч 2-3 жил алслан нүүдэллэн оддог байжээ.. **Уншигчдыг юунд итгүүлж, юу хийлгэхийг хүсэж байна вэ?** Тэгвэл өнөөгийн малчид юуны чинь нүүх суух манатай, өмчилж авсан хашаа бууц, худаг усаа сахин, жилийн дөрвөн улиралд нэгэн довон дээрээ эргэлдсэн дошны амьтад болон хувирч байна шүү дээ... тэгэхээр малын хөлийн талхигдлаас үүсэж буй цөлжилтөөс үнэхээр аврагдъя гэж бодож байгаа л бол байгаль эхийн энэ дотоод зохицуулалтыг хүлээн зөвшөөрч, оготно олшроод ирэхийн цагт нутаг сэлгэн, алслан нүүж хөрсөө амрааж байхаас өөр арга зам байхгүй гэдгийг харуулаад байна. Энэ бол бэлчээрийн даац хэтэрсэнээс үүсэж буй цөлжилтөөс аврагдах цорын ганц арга зам бол үлийн цагаан оготны хэт олшролт гэдгийг харуулж байна... Эцэст нь хэлэхэд эх байгальд маань устгуулж байх ёстой тийм илүүдэл хэрэгцээгүй амьтад гэж хаана ч хэзээ ч байдаггүй бөгөөд харин өнөөдөр устгуулж хорогдуулахаас өөр аргагүйд хүрч мэдэхээр нэг аймшигт амьтад гарч ирсэн нь эх байгалиа сүйтгэж байгаагаараа хүн өөрөө болчихож тун болзошгүй байна шүү гэдгийг л онцлон хэлмээр байна. **Уншигчийн ёс суртахууны мэдрэмжид зохиогч хэрхэн хандаж байна вэ?** Ж. Арилдэмбэ: Ер нь аливаа асуудлын талаар уншигчдад зөв буруугийн мэдрэмж сэтгэгдлээ төрүүлэх, үзэл бодлыг нь хөтлөн чиглүүлэхэд зохиогчоос өгүүлж буй зүйлдээ хэрхэн хандаж байгаагаа үг хэллэгийн сонголт, найруулгын утга, уран дүрслэлийн арга хэрэглүүрээр илтгэж байдаг. Тухайлбал, зохиогч уг нийтлэлд үлийн цагаан оготныг: Хорголжин бор нүдэт, Бяцхан амьтад, Гайхамшигт технологичийн үүрэг гүйцэтгэгч, Ачтан буянтан, Хурдан шалмаг, Нөр их хөдөлмөрч, Гайхамшигт технологичид, Цагаан нөмрөгт гоо сайханчид хэмээн гадаад, дотоод шинж, чанарыг тодотгож, хүншүүлэн дүрсэлсэн нь зохиогчийн хандлага, үнэлэмж хийгээд нотлон итгүүлэх зорилгоос үүдэлтэй бөгөөд ингэснээрээ уншигчдад үлийн цагаан оготны талаар тодорхой дүрслэл, зэрэг ойлголт өгөхийн сацуу өрөвдөн энэрэх сэтгэл төрүүлэхүйц утга чанартай ч болж байгаа юм. Ер нь зохиогчийн санаа зорилго ч тийм.

Гэрийн даалгавар



Эсээний бүтцийн дагуу хэнд хандаж бичих вэ, ямар сэдвээр бичих вэ, ямар зорилготой бичих вэ, ямар эх сурвалж ном зохиолоос судлах вэ, гэх зэргийг харгалзан үзэж ятгасан эсээ бичээрэй.

